

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 17-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН
ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООДЫН
ХАМТАРСАН

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4 – 5

1. *Байнгын хороодын хамтарсан тогтоолын төсөл /Шинжээч
томилох тухай/*

4 – 5

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Эдийн засгийн байнгын
хороодын 9 дүгээр сарын 17-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хамтарсан хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хамтарсан хуралдаанд ирвэл зохих 57 гишүүнээс 30 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 30 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: М.Энхцэцэг;

Чөлөөтэй: Н.Алтаншагай, С.Амарсайхан, Г.Ганбаатар, С.Ганбаатар, М.Ганхүлэг, Ц.Мөнхбат, Т.Мөнхсайхан, З.Мэндсайхан, С.Одонтуяа, У.Отгонбаяр, С.Цэнгүүн;

Эмнэлгийн чөлөөтэй: Ч.Анар, Б.Бат-Эрдэнэ, Ж.Ганбаатар, Ч.Лодойсамбуу, Э.Одбаяр, Ц.Идэрбат, Л.Соронзонболд, Б.Тулга;

Тасалсан: Ж.Алдаржавхлан, Ц.Баатархүү, М.Бадамсүрэн, Х.Булгантуяа, Б.Жаргалан, Б.Пунсалмаа, О.Цогтгэрэл.

***Нэг.Байнгын хороодын хамтарсан тогтоолын төсөл
/Шинжээч томилох тухай/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, Ж.Түвшинжаргал, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, референт Б.Ууганцэцэг, М.Элбэгдорж, Х.Шижирмөнх, М.Мандхай нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар “Шинжээч томилох тухай” Байнгын хороодын хамтарсан тогтоолын төслийг хаалттай горимоор хэлэлцье гэсэн горимын санал гаргав.

Б.Бейсен: Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 13
Бүгд: 30
56.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хороодын хамтарсан хуралдаан 09 цаг 33 минутаас хаалттай горимд шилжив.

Хамтарсан нээлттэй хуралдаан 04 минут үргэлжилж, 57 гишүүнээс 30 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр 09 цаг 34 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН,
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхим
09 цаг 30 минут

ЭДИЙН ЗАСГИЙН БОЛОН БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Бейсен: Эрхэм гишүүдэд өглөөний мэндийг хүргэе.

Байнгын хорооны гишүүдийн олонхын хүрэлцэн ирж, ирц 50.9 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн хамтарсан хуралдааныг нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-ын дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Очирбатын Амгаланбаатар ирсэн байна, Жигжидийн Батжаргал гишүүн ирсэн байна, Пүрэвийн Батчимэг гишүүн ирсэн байна, Пүрэвжавын Ганзориг гишүүн ирсэн байна, Сонгобайн Замира гишүүн ирсэн байна, Сүрэнжав Лүндэг гишүүн ирсэн байна, Бадрахын Найдалаа гишүүн ирсэн байна, Ренчинбямбаагийн Сэддорж гишүүн ирсэн байна, Агваанлуvsангийн Ундраа гишүүн ирсэн байна, Мөнхчулууны Энхцэцэг гишүүн ирсэн байна, Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна, Отгоншарын Батнайрамдал гишүүн ирсэн байна, Буланы Бейсен гишүүн ирсэн байна, Гонгорын Дамдинням гишүүн ирсэн байна, Батжаргалын Заяабал гишүүн ирсэн байна, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн ирсэн байна, Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн байна, Цэвэгдоржийн Туваан гишүүн ирсэн байна, Болдын Уянга гишүүн ирсэн байна, Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн ирсэн байна, Ринчиндоржийн Батболд гишүүн ирсэн байна, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн ирсэн байна, Шинэбаярын Бямбасүрэн гишүүн ирсэн байна, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн ирсэн байна, Жаргалсайханы Золжаргал гишүүн ирсэн байна, Баатаржавын Мөнхсоёл гишүүн ирсэн байна, Ганбатын Очирбат гишүүн ирсэн байна, Буяагийн Тулга гишүүн ирсэн байна, Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн ирсэн байна.

Байнгын хорооны хамтарсан хуралдааны хэлэлцэх асуудал танилцуулъя.

Байнгын хорооны тогтоолын төсөл. Шинжээч томилуулах тухай. Сонсгол явуулах Байнгын хорооны дарга бид 7 сарын 08-ны өдрийн хамтарсан хуралдаанаар томилсон байгаа.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу? Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн байхгүй байна.

“Шинжээч томилох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-д Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.3-д заасны дагуу хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэж болно гэж заасан байгаа. Саналтай гишүүн байна. Энд.

Б.Баярбаатар гишүүн санал гаргаж байна. Б.Баярбаатар санал хэлье.

Б.Баярбаатар: Хоёр Байнгын хорооны гишүүддээ өглөөний мэндийг хүргэе.

Өнөөдөр бас хамтарсан Байнгын хороо хуралдаж асуудал хэлэлцэх гэж байгаад талархаж байна.

Тэгээд хувь хүнтэй холбоотой асуудал, шинжээч томилох, нөлөөлөл гээд олон зүйлүүд байгаа учраас энэ асуудлыг хаалттай горимоор хэлэлцэх горимын санал гаргаж байна. Дэмжиж өгнө үү.

Б.Бейсен: Б.Баярбаатар гишүүний гаргасан горимын саналын дагуу санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдээрэй.

Саяын горимын саналаар хаалттай хуралдах хуралдаанаар санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

17 гишүүн дэмжиж, 56.7 хувиар дэмжигдсэн тул хуралдааныг хаалттай горимд шилжүүлье.

Хамтарсан хуралдаан 4 минут үргэлжилж, 09 цаг 34 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД